



МОНОС ХҮНС ХУВЬЦААТ КОМПАНИ

**“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

Улаанбаатар
2024 оны 12 дугаар сарын 31

Нэг. ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ХУВЬ

1.1. Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145 тоот тогтоолоор “Компанийн засаглалын кодекс” -ийг шинэчлэн батлаж, нээлттэй хувьцаат компани, даатгагч, банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ болон хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхэлдэг компаниудыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөхийг зөвлөсний дагуу Монголын Хөрөнгийн Биржийн гүйцэтгэх захирлын 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/58 тоот тушаалаар “Компанийн засаглалын кодекс”-ийг үнэлэх аргачлалыг батласан. Уг аргачлалын дагуу “Монос хүнс” ХК -ийн “Компанийн засаглалын кодекс” -ийн хэрэгжилтийн үнэлгээг ТУЗ-өөс хийн хүргүүлж байна.

1.2. Үнэлгээний асуулгын бүтэц:

- 1 -р зарчим. ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт
- 2 -р зарчим. ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг
- 3 -р зарчим. Тайлагнал, мэдээллийн ил тод байдал
- 4 -р зарчим. Аудит, хяналтын тогтолцоо
- 5 -р зарчим. Эрсдэлийн удирдлага
- 6 -р зарчим. Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал
- 7 -р зарчим. Оролцогч талуудын эрх ашиг
- 8 -р зарчим. Компанийн соёл
- 9 -р зарчим. Хувьцаа эзэмшигчдийн эрх

1.3. Үнэлгээний өнөө, нэгдсэн үнэлгээ:

Асуулга тус бүрийн хувьд доорх оноогоор үнэлж, үнэлгээг хувиар тооцож гаргасан.

- бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан 2,
- хэсэгчлэн хэрэгжүүлсэн, хугацаа заасан, авах арга хэмжээ, зорилгоо тайлбарласан 1,
- үнэлгээ өгөөгүй бол 0

Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ:

- авбал зохих нийт онооны 90% - түүнээс дээш -- засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
- 70% - 89% --дунд засаглалтай, цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
- 50% -69% -- хангалтгүй засаглалтай, эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
- 49% - түүнээс доош -- муу засаглалтай, үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

Хоёр. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар

№	Зарчим	Авбал зохих оноо	Компанийн үнэлгээ /2024-12-31/	Хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12	100%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10	100%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100%
5	Эрсдэлийн удирдлага	8	7	87.5 %
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6	100%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100%
8	Компанийн соёл	6	6	100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10	100%
НЭГДСЭН ДҮН		72	71	
		100%	98.6%	

Дээрх хүснэгтэд заасан үнэлгээнээс харахад Монос хүнс ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээ нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 98.6 % буюу хэвийн засаглалтай гэсэн ангилалд багтаж байна.

Гурав. ҮНЭЛГЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
/ МОНОС ХҮНС ХК/

2024.12.31

Улаанбаатар хот

Компанийн засаглалын үнэлгээний асуулга					
<i>Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана..</i>					
НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ					
ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна					
№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн. “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-д зохицуулалтыг тусгасан. Уг журмыг 2019 онд батласнаас хойш үйл ажиллагаандаа нийцүүлэн 3 удаа /2021-05-17, 2023-05-10, 2024-11-22/ нэмэлт өөрчлөлт оруулаад байна.	2024-04-20 өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 03 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам 2019-8-26 өдрийн 12/08 тоот ТУЗ тогтоолоор баталсан, 2021-05-17 өдрийн 06/05, 2023-05-10 өдрийн 05/05, 2024-11-22 өдрийн тоот ТУЗ тогтоолын хавсралтаар КЗК-ийн 1.1 зарчимд нийцүүлэн нэмэлт өөрчлөлтийг оруулсан. Журамд ТУЗ-ийн бүрэлдэхүүний болон хороод, хараат бус гишүүдийн чиг үүргийг нарийвчлан зохицуулсан заалтыг тусгасан. Мөн журмын 2.2.15 заалтаар ТУЗ-ийн гишүүд компанийн санхүү, үйл ажиллагаа, ТУЗ-ийн үйл ажиллагааг сайжруулах хүрээнд хөндлөнгийн мэргэжлийн этгээдийн зөвлөгөө сургалт авах, хөндлөнгийн аудит хийлгэх эрхийг тусгаж өгсөн. Энэ тохиолдолд зардлыг компани даахаар зохицуулсан байна. Нотлох баримт: 1. Компанийн дүрэм /2024-04-20 №03/ 2. ТУЗ ҮАЖ /2024-11-22 №24/21/	2	100%
2	1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.	Бүрэн хэрэгжүүлсэн. Компанийн дүрэм, “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-д ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалттай холбоотой заалтыг бүрэн тусгасан. 2023-08-31 өдрийн 17/08 тоот ТУЗ-ийн тогтоолын хавсралтаар “Залгамж халааны бодлого” баримт бичгийг батлав.	2024-04-20 өдрийн ХОЭХ-аас компанийн дүрмийн 7.15-д нэмэлт өөрчлөлт оруулан ТУЗ дэргэдэх хороодыг 1.Аудит, эрсдэлийн хороо, 2. Нэр дэвшүүлэх хороо, 3. Стратеги, бизнес хөгжлийн хороо, 4. Цалин урамшууллын хороо гэж нэрлэн 4 хороотой болгосон. ТУЗ-ийн гишүүний томилгоо, сонгон шалгаруулалттай холбоотой нарийвчилсан зохицуулалтыг 2024-11-22 өдрийн ТУЗ-ийн хурлаас батласан тогтоолын хавсралт “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-д тусган, хэрэгжилтийг ТУЗ-ийн дэргэдэх бие даасан Нэр дэвшүүлэх хороо зохион байгуулан ажиллаж байна. Мөн компанийн дүрэмд хараат бус гишүүдийн	2	100%

			тоог нэмэгдүүлж 11 болгосонтой холбоотой ТУЗ-ийн хараат болон хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалт, томилгоог КТХ болон дүрэм, журамд нийцүүлэн ажиллаж байна. 2023-08-31 өдрийн ТУЗ-ийн ээлжит бус хурлаар Залгамж халааны бодлогын баримт бичгийг хэлэлцүүлэн батлуулж мөрдөн ажиллаж байна. Уг журамд, эрх бүхий албан тушаалтны залгамж халааны зохицуулалтыг тусгасан. Нотлох баримт: 1. Компанийн дүрэм /2024-04-20 №03/ 2. ТУЗ ҮАЖ /2024-11-22 №24/21/ 3. Залгамж халааны бодлого /2023-08-31 №17/08/		
3	1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсанд аа байршуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн, компанийн албан ёсны вэб хуудаст хандсан хувьцаа эзэмшигчид, хоронго оруулагчид, бусад харилцагчид ТУЗ-ийн гишүүдийн мэдээллийг дэлгэрэнгүй танилцах боломжтойгоор талбарт байршуулсан	ТУЗ гишүүдийн хувьцааны эзэмшил, ажлын туршлага, боловсрол, хараат бус байдлын мэдээллийг компанийн албан ёсны вэб хуудас болон МХБ сайт нээлттэй байршуулсан байгаа, компанийн улирал бүрийн тайлан дээр гишүүдийн мэдээллийг тавьж байгаа. Компанийн вэб хуудаст ТУЗ-ийн хурлын товч мэдээлэл, хурлаар хэлэлцсэн асуудал зэргийг нээлттэй тайлагнаж байна. Оны эцэст ТУЗ-ийн гишүүн бүрээс бие даасан тайланг авч байна. Нотлох баримт: 1. ТУЗ жилийн эцсийн хурлын мэдээ- / https://monosfoods.mn/news/monos-h-ns-huvcaat-kompanijn-t-l-l-n-udirdah-z-vl-lijn-eelzhit-hural-bolloo/, 2. https://monosfoods.mn/investor#zuwlul 3. https://mnc.mn/mn/company/551 4. ТУЗ болон хороодын 2024 оны тайлан 5. ТУЗ-ийн гишүүдийн тайлан	2	100%
4	1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн, компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам зэрэгт хороодын бүтэц, гишүүдийн харьцаа, ТУЗ гишүүнд тавигдах шаардлага зэргийг тодорхой тусгаж өгсөн. Эдгээр ББ тусгасны дагуу шаардлагыг тавьж ТУЗ гишүүний сонгон шалгаруулалтыг нээлттэйгээр зарлан шалгаруулалтыг хийдэг.	Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс 2024-04-20 өдөр хуралдсан ХЭЭХ-аар ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тоог нэмэгдүүлэн 5 болгосон, ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүтцийг өөрчлөн 4 болгосон зэрэг заалтыг тусгасан дүрмийн өөрчлөлтийг хэлэлцүүлэн батлуулж, СЗХ-оор хянуулж УБЕГ-ын ХЭБГ-т бүртгүүлж хүчин тогтоодор болсон. Дүрмийн хэрэгжилтийг хангах үүднээс ТУЗ дэргэдэх НДХ хуралдаж ТУЗ хараат бус гишүүнд тавигдах нөхцлийг тодорхойлж, сонгон шалгаруулалтын зарыг 1 сарын хугацаатайгаар нээлттэй зарласан. Зарын дагуу 28 хүнээс анкет мэдээлэл ирүүлсэн бөгөөд Энэ процессын дагуу 2024-06-05-ны өдрөөс 1 сарын хугацаатайгаар нээлттэй сонгон шалгаруулалт зарласан. 28 хүнээс анкет мэдээлэл ирүүлснээс НДХ-оос 13 хүнийг эхний шалгуураар сонгон шалгаруулж 2024-09-09 өдрийн	2	100%

			ХЭЭБХ-аас 5 хүнийг ТУЗ хараат бус гишүүнээр сонгосон. ТУЗ-ийн ҮАЖ-д гишүүдийн хараат бус байдлыг хангах болон гишүүдийн хүйсийн харилцаа тэнцвэрт байдлыг хадгалах бодлогыг баримтлах заалтуудыг тусгасныг мөрдөж байна. Одоо ажиллаж байгаа ТУЗ-ийн 11 гишүүний 5 нь эрэгтэй, 6 нь эмэгтэй гишүүд юм. Нөтлөх баримт: 1. Компанийн дүрэм /2024-04-20 №03/ 2. ТУЗ ҮАЖ /2024-11-22 №24/21/ 3. ТУЗ хараат бус гишүүний зар / https://monosfoods.mn/news/tuz-ijn-haraat-bus-gish-nij-songon-shalgaruulaltyn-zar/ 4. ТУЗХ-ын тэмдэглэл /2024-08-07 №05/ 5. ХЭЭБХ-ын тэмдэглэл /2024-09-09 №04/ 6. ТУЗ хурлын тогтоол /2024-09-18 №15/		
5	1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.	Бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна.	Монос хүнс ХК-ийн ТУЗ нь компанийн засаглалын чиглэлээр сургалтанд бүрэн хамрагдаж гэрчилгээ авсан, бусад компаниудад ТУЗ-ийн дарга, гишүүдийн үүргийг давхар хашдаг, энэ талын боловсрол чадвартай гишүүдээс бүрддэг. ТУЗ-ийн хараат гишүүн, Монос хүнс ХК-ийн 70%-ийн хувьцаа эзэмшигч Л.Хүрэлбаатар нь МУ-ын Хөдөлмөрийн баатар, ШУ-ы доктор, профессор, Монос группын компаниудын хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн даргаар ажилладаг, НДХ-ы дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Энхжаргал нь Монгол банк болон ХК-уудын ТУЗ хараат бус гишүүнээр ажиллаж байсан, Аудит эрсдэлийн хорооны дарга ТУЗ-ийн хараат бус гишүүн Г.Золжаргал ҮЦК-д удирдах ажилтнаар, хараат бус гишүүн Н.Улаанхүү МХБиржийн хараат бус гишүүн, Аудит хорооны даргаар ажилладаг, хараат бус гишүүн М.Сарандаваа БОНЗ-ын чиглэлээр EBRD санхүүжилтээр монголын ХК-уудад зөвлөх үйлчилгээ, сургалт олгодог, хараат гишүүн Ч.Баттогтох АШУҮИС-ийн Бионагаахын хүрээлэнгийн захирал, дэд профессор зэрэг мэдлэг чадвартай гишүүдээс бүрдэж байна. 2024-04-20 өдрийн ХЭЭХ-ын №02 тоот тогтоолоор ТУЗ-ийн 2024 оны төсвийг батлахдаа 2 сая төгрөгийг сургалтын зардалд төсөвлөн батлуулсан бөгөөд ТУЗ-ийн гишүүдэд зориулсан жилийн сургалтын төлөвлөгөөг гарган батлуулж Компанийн Засаглалын хөгжлийн Төв (CGDC)-тэй хамтран ТУЗ гишүүдэд сургалт орохоор төлөвлөж байсан боловч гишүүд бүрэлдэхүүн өөрчлөгдсөн тул сургалтын байгууллагуудад хандан	2	100%

			сургалтын хугацааг өөрчлөн зохион байгуулахаар ажиллаж байна. Нотлох баримт: 1. https://monosfoods.mn/investor#zuwlul тайлбар: компанийн вэб хуудасны ТУЗ талбарт ТУЗ гишүүдийн доорх “дэлгэрэнгүй” товчлуур дээр дарахад мэдээлэл нээгдэх тохиргоо хийгдсэн. 2. https://mse.mn/issuers/shiidber/551_2024-04-20%2011:00hnh_togtool1550630716.pdf 3. ТУЗ хараат болон хараат бус нэр дэвшигчид мэдээлэл		
6	1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн, компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, ТУЗ-ийн хурлын дэг зэрэг барим бичгээр зохицуулж өгсөн	Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.20-7.23 заалт, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамын 13 дугаар зүйлд мөрдвөл зохих ёс зүйн хэмжээг тусгаж өгсөн. Нотлох баримт: 1. Компанийн дүрэм /2024-04-20 №03/ 2. ТУЗ ҮАЖ /2024-11-22 №24/21/ 3 ТУЗ-ын хурлын дэг /2019-07-20 №05/07/	2	100%
ДҮН				12	100%
ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ					
7	2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	КТХ-д заасны дагуу ТУЗ-ийн гишүүдийн 1/3 нь хараат бус гишүүд, ТУЗ-ийн дэргэдэх хороодын 2/3 нь хараат бус гишүүд, хороодын дарга нар нь хараат бус гишүүдийг томилсноор шийдвэр гаргалтанд хараат бус гишүүдийн идэвх оролцоо, саналыг голлон анхаарч байна. Ингэснээр жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах боломжийг ханган ажиллаж байна. 2024-04-20-ны ХЭЭХ-аар компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тоог 2-оор нэмэгдүүлж 5 болгосон.	Компанийн засаглалын кодексын энэхүү шалгуурыг хангах үүднээс 2024-02-16 өдөр хуралдсан ТУЗ-ийн хурлаас ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тоог нэмэгдүүлэхээр ХЭЭХ-ийн хэлэлцүүлэх асуудалд оруулах, компанийн дүрэмд тусгах шийдвэрийг гарган, 2024-04-20 өдөр хуралдсан ХЭЭХ-ын №03 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан дүрмийн 7.2 заалтад 11 гишүүнтэй, үүнээс 5 гишүүн хараат бус гишүүн байхаар тусгаж өгсөн. Энэ заалтын хэрэгжилтийг хангах үүднээс 2024-09-09 өдөр ХЭЭБХ-ыг зарлан хуралдуулж ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар дахин сонгосон. Компани одоо ажиллаж байгаа хараат бус гишүүдийг олон нийтэд нээлттэйгээр зарлаж, ХЭХ-аар хэлэлцүүлж сонгосон, мөн ердийн 1 гишүүн нь жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл бөгөөд ТУЗ-ийн гишүүдийн 4 нь нэгдмэл сонирхолтой бус гишүүд юм. ТУЗ-ийн хурлаас гаргах шийдвэр гаргалтыг хараат бус гишүүдийн санал, шийдвэрт голлох зорилгоор ТУЗХ-аар хэлэлцэх асуудлыг ТУЗ-ийн дэргэдэх хороодоор эхлэн хэлэлцүүлдэг учир хороодын гишүүдийн дийлэнх хувийг хараат бус гишүүдээс бүрдүүлж, хорооны даргыг хараат бус гишүүдээс сонгон удирдуулж байна. Үүнд: АЭХ-ы даргаар хараат бус гишүүн Г.Золжаргал /хороо 5 гишүүнтэй 3 нь хараат бус/,	2	100%

			НДХ-ы даргаар хараат бус гишүүн Д.Энхжаргал /хороо 3 гишүүнтэй 2 нь хараат бус/, СБХХ-ы даргаар хараат бус гишүүн Д.Гэрэлт-Од /хороо 5 гишүүнтэй 3 нь хараат бус/ нарыг сонгосон. Нотлох баримт: 1. Компанийн дүрэм /2024-04-20 №03/ 2. ТУЗ хурлын тогтоол /2024-09-18 №15/		
8	2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.	Бүрэн хэрэгжүүлсэн, Хорооны үйл ажиллагааг ТУЗ-ийн журамд тусган зохицуулсан, компанийн шинээр батлагдсан дүрэмд Аудитын хорооны чиг үүрэг эрсдэлтэй холбоотой чиг үүргийг нэмж тусган хороог Аудит эрдэлийн хороо (АЭХ) гэж нэрлэсэн, гишүүдийн тоог нэмж 5 гишүүнтэй. 3 нь хараат бус гишүүн, хорооны дарга нь хараат бус гишүүн даргаар ажиллаж байна.	ТУЗ-ийн дэргэдэх Аудит, эрсдэлийн хороо нь дэргэдээ гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих зорилгоор дотоод аудиторыг ажиллуулдаг бөгөөд бие даасан “Дотоод аудитын дүрэм”, дотоод аудитын жилийн төлөвлөгөөг гарган батлаж ажилладаг. Хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Г.Золжаргалыг сонгосон. Тус хороо нь 2023 онд 9, 2024 онд 5 удаа хуралдаж, гүйцэтгэх удирдлага, компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналтаа тавьж ажиллаж байна. Хорооны хурлыг өргөн бүрэлдэхүүнээр хуралдах үед шаардлагатай КЭБАТ болон албан тушаалтнуудыг оролцуулдаг. Нотлох баримт: 1. Компанийн дүрэм /2024-04-20 №03/ 2. ТУЗ ҮАЖ /2024-11-22 №24/21/ 3. Дотоод аудитын дүрэм /2021-05-17 №04/05/ 4. https://monosfoods.mn/news/dotood-audityn-jlchilgee-z-leh-sanal-avah-tender/. 5. Мүүр аудит ХХК-ийн 2022 оны худалдан авалтын үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын гэрээт ажлын тайлан 6. Монос групп ХХК-ийн дотоод аудитын газрын тайлан	2	100%
9	2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны	Хорооны бүтцийн өөрчлөлтийг дүрэмдээ тусган батлуулж ТУЗ-ийн 2024-09-18 өдрийн анхны хураллаанаар ТУЗ-ийн дэргэдэх хороодын дарга, гишүүдийг сонгон баталсан. Мөн хороодын үйл ажиллагааг ТУЗ ҮАЖ болон хороодын бие даасан журмаар зохицуулж байна.	Компанийн өмнөх үнэлгээг СЗХ-оос хянаад ирүүлсэн зөвлөмж болон КТХ-д нийцүүлэн цалин урамшууллын хороо нь нэр дэвшүүлэх хороотой хамт байсныг салгаж дүрмийн өөрчлөлтөд тусган батлуулсан. 2024-09-18 өдрийн ТУЗ-ийн /шинэ бүрэлдэхүүний анхны хурал/ хурлаас 4 хороог байгуулж Цалин урамшуулал болон Нэр дэвшүүлэх дэвшүүлэх хороог бие даасан хороо болгон салгаж, хорооны дарга, гишүүдийг сонгосон. Хорооны даргаар Х.Ананд 2 хараат бус гишүүний хамтаар сонгогдсон. Хороо нь КЭБАТ-ы цалин урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, хэрэгжилтэнд хяналт тавих, сар бүрийн ГЗ-ийн гүйцэтгэлийг дүгнэх, компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх, КЭБАТ-ы цалин урамшууллын дээд хязгаарыг тогтоох чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.	2	100%

	хүсэлтээр оролцно.		Нотлох баримт: 1. Компанийн дүрэм /2024-04-20 №03/ 2. ТУЗ ҮАЖ /2024-11-22 №21/ 3. ТУЗ хурлын тогтоол /2024-09-18 №15/		
10	2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	Хорооны бүтцийн өөрчлөлтийг дүрэмдээ тусган батлуулсан. Хорооны үйл ажиллагааг ТУЗ-ийн журамд тусган зохицуулсан, Хороо 3 гишүүнтэй 2 нь хараат бус гишүүн, хорооны дарга нь хараат бус гишүүн Д.Энхжаргал даргалж байна.	Компанийн өмнөх үнэлгээг СЗХ-оос хянаад ирүүлсэн зөвлөмж болон КТХ-д нийцүүлэн цалин урамшууллын хороо нь нэр дэвшүүлэх хороотой хамт байсныг салгаж дүрмийн өөрчлөлтөд тусган батлуулсан. 2024-09-09 өдрийн ХЭЭБХ-аар ТУЗ гишүүдийг сонгох асуудлыг хэлэлцэн хараат 6, хараат бус 5 нийт 11 гишүүнийг сонгосон. Хараат 6 гишүүн улиран сонгогдсон. Хараат бусаар шинээр 5 гишүүнийг сонгосон. ТУЗ гишүүнийн сонгон шалгаруулах, үнэлэх, улируулан сонгох, дуусгавар болохтой холбоотой чиг үүргийг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо хэрэгжүүлэхээр тусган ажиллаж байна. Хорооны дарга хараат бус гишүүн Д.Энхжаргал хорооны 2024-2027 оны хийх ажлын төлөвлөгөөг гарган гишүүдийн хамтаар батлаж, төлөвлөгөөндөө ТУЗ гишүүдийг чадавхижуулах, цалин урамшуулал, хараат бус байдлыг хангах, идэвх оролцоог нэмэгдүүлэх, үнэлэх зэрэг ажлуудыг хийхээр тусгаад байна. Нотлох баримт: 1. Компанийн дүрэм /2024-04-20 №03/ 2. ТУЗ ҮАЖ /2024-11-22 №21/ 3. Залгамж халааны бодлого /2023-08-31/ 4. ТУЗ хурлын тогтоол /2024-09-18 №15/	2	100%
11	2.5. ТУЗ дэргэдээ бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	Бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна. СБХХ-ы чиг үүргийг компанийн дүрэм болон ТУЗ ҮАЖ-д тусган зохицуулсан. Хороо нь компанийн стратеги төлөвлөлт, хувьцаатай холбоотой бодлого төслийн талаар шийдвэр зовломж гаргах чиг үүрэгтэй	ТУЗ-ийн дэргэд Стратеги, бизнес хөгжлийн хороо гэсэн 5 гишүүнээс бүрдсэн хороотой, хорооны дарга нь ТУЗ хараат бус гишүүн Д.Гэрэлт-Од. Энэ хороогоор компанийн урт болон богино хугацааны стратеги, ирэх жилүүдийн санхүүгийн төсөв, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцүүлэн батлуулж байна. Нийт хороодын чиг үүргийг компанийн дүрэм болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд зааж өгсөн. Хороодын гишүүдийн дийлэнх хувь нь (3/5) хараат бус гишүүдээс бүрддэг. Нотлох баримт: 1. Компанийн дүрэм /2024-04-20 №03/ 2. ТУЗ ҮАЖ /2024-11-22 №21/ 3. ТУЗ хурлын тогтоол /2024-09-18 №15/	2	100%
ДҮН				10	100%
ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ					
12	3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал,	Бүрэн хэрэгжүүлсэн Компанийн засаглалын	КТХ, ҮЦЗЗТХ болон эрх бүхий байгуулагуудаас гаргасан журамд заасан хугацаанд компанийн засаглалын болон	2	100%

	тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	хөтөлбөрт тусган улмаар 2023 оны 3-р улирлын ээлжит хурлаар “Мэдээллийн үйл ажиллагааны журам”-ыг батлуулсан.	үйл ажиллагаа, санхүүгийн мэдээллийг тогтмол нээлттэйгээр тайлагнадаг. Монголын Хөрөнгийн Биржийн сайт, компанийн вэб хуудаст санхүү тайлан үйл ажиллагааны тайлан, байгаль орчин, нийгэм, засаглалын тайлан мэдээллийг байнга байршуулдаг. Биет хэлбэрээр зохицуулагч байгууллагад тайлант хугацаандаа хүргүүлж хянуулж байна. Мөн МХБ-ийн ТУЗ-ийн 2024-10-04 өдөр батлагдсан “Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам”-дагуу хугацаат болон нийтэд мэдээлэх шаардлагатай тайлан мэдээллийг хугацаанд нь тайлагнан ажиллаж байна. 2023-08-31 өдрийн 17/08 тоот ТУЗ-ийн тогтоолын хавсралтаар батлагдсан “Мэдээллийн үйл ажиллагааны журам”-ыг МХБ-ийн журамд нийцүүлэн өөрчлөлт оруулан шинэчлэх асуудлыг хэлэлцүүлэхээр бэлдээд байна. Нотлох баримт: 1. https://mse.mn/mn/company/551/ 2. https://monosfoods.mn/investor#sanhuugii-n-medeelel/ 3. https://monosfoods.mn/investor#tailan/ 4. Мэдээллийн үйл ажиллагааны журам / 2023-08-31 №08/		
13	3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн, компанийн албан ёсны вэб хуудсаар дамжуулан засаглалын баримт бичиг, дүрэм, журмыг олон нийтэд нээлттэйгээр түгээж байна.	Компанийн улирлын тайланг компанийн вэб хуудсын “Мэдээ мэдээлэл” талбарт тухай бүрд мэдээлж байсан. Мөн “Хувьцаа эзэмшигчдэд” талбарыг шинээр нэмж үүсгэн хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдад чиглэсэн үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан, засаглалын баримт бичиг, Компанийн засаглалын кодексын хэрэгжилтийн тайлан, дүрэм журам, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл, ТУЗ тогтоол, зар мэдээ зэргийг байршуулах талбар болгон тогтмол мэдээллийг шинэчлэн байршуулж эхлээд байна. Мөн ТУЗ-ийн шийдвэр гаргалт, хэлэлцсэн асуудлын талаар хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдад мэдээллийг тухай бүр хүргэх үүднээс ТУЗХ-ыг хуралдсан өдөртөө мэдээллийг оруулж хэвшээд байна. Нотлох баримт: 1. https://monosfoods.mn/investor#tailan 2. https://monosfoods.mn/investor#sanhuugii-n-medeelel 3. https://monosfoods.mn/news/monos-h-nshk-ijn-2025-ony-biznes-t-l-vl-g-g-tuz-ijn-eelzhit-hurlaar-helelc-len-batallaa 4. https://monosfoods.mn/investor-blog	2	100%
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй,	Компанийн улирлын үйл ажиллагаа, санхүү, байгаль орчин,	Санхүүгийн тайланг хуульд заасан хэлбэрээр хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч нарт ойлгомжтой хувилбараар тогтмол тайлагнаж, жил, улирлын	2	100%

	тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна. https://monosfoods.mn/investor-blog	нийгэм, засаглалын тайлан зэргийг Монголын Хоронгийн Биржийн сайт, компанийн албан ёсны вэб хуудас болон мэдээллийн бусад сувгаар танилцуулга, мэдээллийг түгээн хэвшүүлсэн.	төлөвлөгөөг гүйцэтгэл, эсрэг, сөрөг дүгнэлтийн хамт ТУЗ-д хэлэлцүүлж баталгаажуулсан тайланг олон нийтэд тогтмол хугацаанд нь тайлагнадаг. Монос хүнс ХК нь компанийн үйл ажиллагаанаас үүсэж буй байгаль орчин, нийгэм засаглал (БОНЗ/ESG)-ын нарийвчилсан суурь үнэлгээ хийлгэж, нийт 225 шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийлгэснээс 153 шалгуур бүрэн биелсэн, 24 шалгуур бүрэн бус, 48 шалгуур биелээгүй буюу компанийн БОНЗ үнэлгээ 68% биелэлттэй гэж дүгнэсэн тайлангийн хураангуйг компанийн вэб хуудаст тавьж тайлагнасан. Мөн үйл ажиллагааны болон нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн ажлуудын тайланг вэб хуудас, пэйж, фэйсбүүк группт тогтмол байршуулан мэдээлж байна. Нотлох баримт: 1. Санхүүгийн тайлан / https://monosfoods.mn/investor#sanhuugiin-medecelel/ 2. БОНЗ-ын тайлан / https://monosfoods.mn/investor#tailan/ 3. Үйл ажиллагааны тайлан https://monosfoods.mn/investor#tailan 4. https://monosfoods.mn/news/henegtej-mongol-er-h-n-t-s-l-social-impact-2024-arga-hemzheend-urilgaar-orolcozh-turshlagaasaa-huvaalcлаa 5. https://monosfoods.mn/news/monos-h-ns-hk-b-teegdeh-nee-kirgiz-ulsad-alban-yosoor-hudaldaalzheellee 6. https://monosfoods.mn/news/huvcaa-ezemshigchdijn-eelzhit-bus-hurlvn-medecelel 7. https://monosfoods.mn/news/monos-h-ns-hk-shine-b-reldeh-ntejgeer-tuz-ijn-anhdugaar-hurlaa-hijlee 8. https://monosfoods.mn/news/monos-h-ns-hk-ijn-2025-ony-biznes-t-l-vl-g-g-tuz-ijn-eelzhit-hurlaar-helelc-len-batallaa 9. https://monosfoods.mn/news/monos-h-ns-hk-ijn-chanaryn-hyanaltyn-laboratori-olon-ulsyn-itgemzhlel-h-rtlee 10. https://monosfoods.mn/news/mongol-ulsyn-h-nsnij-manlaj-jldver-ecer-monos-h-ns-hk-shalgarlaa 11. https://monosfoods.mn/news/monos-h-ns-hk-anh-udaa-mfc-tour-arga-hemzheeg-zohion-bajguullaa		
ДҮН				6	100%
ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО					
ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана					
15	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд	Бүрэн хэрэгжүүлсэн, компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл	Компанийн дүрмийн 7.16 заалтад Аудит, эрсдэлийн хорооны эрх үүргийг тусгахдаа хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, хийх ажилд нь чиглэл өгөх,		

	хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	ажиллагааны журамд тусгасан байгаа. Жил бүр санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх компанийг АЭХ-ы хурлаас сонгон шалгаруулж ТУЗХ руу хэлэлцүүлэн батладаг. 2023 онд үйл ажиллагааны аудит /Мүүр аудит ХХК/, хоронгийн үнэлгээ / Овиденсе аудит ХХК/, санхүүгийн аудит /БДО аудит ХХК/, 2024 онд санхүүгийн тайланд /Онч аудит ХХК/ сонгон аудит хийлгээд байна.	гэрээний нөхцлийг тодорхойлох эрх үүргийг тусгаж өгсөн. АЭХ нь жил бүр хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, жилийн эцсийн тайланд аудит хийх үед чиглүүлэн, хамтарч ажиллах, хийсэн дүгнэлтийг хянах, жилийн эцсийн дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дээр тайлагнах, ТУЗ-д танилцуулах зэрэг ажлыг хариуцан гүйцэтгэдэг. 2024-09-24 өдрийн ТУЗ-ийн ээлжит бус хурлаар компанийн 2024 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн хяналт хийх аудитын компанийг сонгон шалгаруулах, гэрээний нөхцлийг хэлэлцэх асуудлыг хэлэлцүүлж “Онч аудит” ХХК-ийг сонгон шалгаруулсан шийдвэрийг гаргасан. Нотлох баримт: 1. Компанийн дүрэм /2024-04-20 №03/ 2. ТУЗ ҮАЖ /2024-11-22 №21/ 3. ТУЗХ-ын тогтоол /2023-11-13 №19/ (хөндлөнгийн аудитын компани сонгох-) 4. ТУЗХ-ын тогтоол /2024-04-12 №02/ (БДО аудит компанийн дүгнэлт батлах) 5. ТУЗХ-ын тогтоол /2024-09-18 №18/ (хөндлөнгийн аудитын компани сонгох)	2	100%
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Бүрэн хэрэгжүүлж хэвшсэн.	2019 онд Монос хүнс ХК хэлбэрээ өөрчлөн нээлттэй хувьцаат компани болсноос хойш жил бүр КТХ-д заасан хугацаанд ХЭЭХ-аа хуралдуулж хуралдаа хөндлөнгийн аудит хийсэн БДО аудит ХХК-ийн гүйцэтгэх удирдлага, хяналт шалгалт хийсэн аудиторыг урин оролцуулж тайланг өөрсдөөр нь тавиулж далсан. 2024-04-20 өдөр хуралдсан ХЭЭХ-ийн танилцуулах асуудалд оруулсан хөндлөнгийн аудитын байгууллагын танилцуулгыг компанийн 2023 оны санхүүгийн тайланд аудит хийсэн “БДО аудит” ХХК-ийн партнер Л.Баярцогзол танилцуулж хувьцаа эзэмшигчдийн асуултанд хариулсан. Нотлох баримт: 1. https://www.facebook.com/photo/?fbid=824314343067828&set=pcb.824315403067722 2. СЗХ рүү ХЭЭХ-ын материал хүргүүлсэн албан тоот, хавсралт хурлын материал /2024-04-24 №208/	2	100%
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон оорчлолтийн талаарх	ТУЗ-ийн дэргэдэх АЭХ-оос компанийн санхүү тайлан, үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх үүрэг бүхий дотоод аудитор орон тоо, цалингийн хэмжээг	ТУЗ-ийн дэргэдэх АЭХ-ы дэргэд дотоод аудитор ажиллах бүтцийг батласан боловч одоогоор ажилтангүй, сонгон шалгаруулалтын зарыг нээлттэйгээр зарлан ажил горилогчидтой ярилцлага хийсээр байна. Ажилтан байхгүй энэ хугацаанд аудитын хорооноос аудитийн зөвшөөрөлтэй компаниудад хандан үйл ажиллагааны аудит хийлгэхээр тендер зарлаж “Мүүр аудит”-ыг сонгон гэрээ	2	100%

	мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.	2020-11-12 өдрийн 25/11 тоот тогтоолоор батлан ажилтан сонгон шалгаруулж аван 2021-05-17 өдрийн 04/05 тоот тогтоолоор “Дотоод аудитын дүрэм”-г батласан. Мөн 2023 оны 4-р сард компанийн худалдан авалтын үйл ажиллагаан дээр хөндлөнгийн аудитын байгууллага “Мүүр аудит” ХХК-аар хяналт хийлгэн зөвлөмж авч сайжруулан ажилласан.	байгуулж худалдан авалтын циклд аудит хийлгэж компанийн худалдан авалтын чиг үүргийг хариуцаж байгаа санхүү, хангамж, бусад албад ажилтнуудын баримталж байгаа баримт бичиг, журам процессын сайжруулалтын хүрээнд Худалдан авалтын журам”-ыг шинэчлэн сайжруулж, зарим процесс зураглал, бүртгэл бичиг баримтыг сайжруулаад байна. Нотлох баримт: 1. Дотоод аудиторын цалинг тогтоох тухай ТУЗ тогтоол /2020-11-12 №25/11/ 2. Дотоод аудитын дүрэм /2021-05-17 №04/05 тоот/ 3. https://monosfoods.mn/news/dotood-audityn-jlchilgee-z-leh-sanal-avah-tender , 4. Мүүр аудит ХХК-аас “Монос хүнс ХК-ийн 2022 оны худалдан авалтын үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын гэрээт ажлын тайлангаас хавсаргав		
ДҮН				6	100%
ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА					
ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина					
18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Компани эрсдэлийг удирдах үйл ажиллагааг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны чиг үүрэгт тусгаж зохицуулсан. Энэ өөрчлөлтийг 2024-04-20 өдрийн ХЭЭХ-аас баталсан дүрмийн өөрчлөлт дээр тусгасан. Мөн компани “Эрсдэлийг удирдах журам” - тай, уг журамд эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, ангилах, компанийн алба нэгжүүд хэрхэн оролцох, эрсдэлээс үүдсэн хохирол, үр дагаврыг тодорхойлох, эрсдэлийн түвшинг бууруулах, арилгах аргачлал, оролцогч талуудын эрх үүрэг хариуцлага зэргийг нарийвчдан тусган зохицуулсан. Компанид	2024-04-20 өдрийн ХЭЭХ-ын №03 тоот тогтоолоор батлагдсан дүрмийн 7.15-7.19-р заалтуудад ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүтэц, бүрэн эрх, чиг үүрэгт нэмэлт өөрчлөлтийг оруулж Аудит, эрсдэлийн хороо гэж байхаар тусгаж өгсөн. Мөн хэсгийн 7.16.6-7.16.9 хүртэл эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны талаар зохицуулах заалтуудыг нэмж оруулсан. Гүйцэтгэх захирлын удирдлага дор ажилладаг эрсдэлийн баг нь үйл ажиллагаагаа ТУЗ-ийн ээлжит хурлаар хэлэлцдэг тайланд тусгаж тайлагнадаг. Компани жилд 2 удаа “Retreat” арга хэмжээг дотооддоо зохион байгуулж, уг арга хэмжээгээр дотоод, гадаад хүчин зүйлд үндэслэн учирч болох эрсдэл, учруулж болох сөрөг нөлөөг тодорхойлох, үнэлэх үйл ажиллагааг хийдэг. Ийнхүү бэлтгэлгүй эрсдэлээ тодорхойлж, үнэлснээр эрсдэлээс зайлсхийх, эрсдэл учирах үед авах хариу арга хэмжээг тодорхойлж ажиллаж байна. 2024 онд компани учирч байгаа болон учирч болох эрсдэлүүдээ тодорхойлж 2 удаа “Retreat” арга хэмжээ /2024-06-25 өдөр “Илүү сайхныг эх дэлхийдээ” нэрийн дор байгаль орчин нийгэм засаглал /БОНЗ/-ын асуудлыг хөндсөн сэдвээр, 2024-10-22-наас 2024-10-23 өдрүүдэд “Highway” гэсэн нэрийн доор компанийн 2025-2027 оны стратеги,	2	100%

		болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах “Эрсдэлийн баг”-ийн ажилладаг.	хэтийн төлөвлөлтийг хэлэлцсэн байдлаар зохион байгуулаад байна. Компани жилд 2 удаа энэхүү арга хэмжээг тогтмол хийхээр төлөвлөж байна. Нотлох баримт: 1. Компанийн дүрэм /2024-04-20 №03/ 2. Эрсдэл удирдлагын журам /ГЗ-ийн 2021.09.15 №20/ 3. Эрсдэлийн баг томилох тухай /ГЗ-ийн 2024-12-05 №А44 тушаал/		
19	5.2. ТУЗ дэргэдээ эрсдэл удирдлагын хороотой байхыг зорих ба уг хороо нь 3-с дээш гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давамжсийн талаар тогтмол тайлагнана.	2024 оны ХЭ-ийн ээлжит хурлаар компанийн дүрмийг шинэчлэн батлаж эрсдэлийн удирдлагыг аудитын хороонд хавсарган чиг үүрэг бүрэн эрхийг тодорхойлон дүрэмд тусгаж өгсөн.	2024-04-20 өдрийн ХЭЭХ-ын №03 тоот тогтоолоор батлагдсан дүрмийн 7.15 заалтаар ТУЗ-ийн дэргэд 4 хороо байгуулж эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг Аудит, эрсдэлийн хороо хариуцан хийж байхаар зохицуулалтыг тусгасан. 2024-09-18 өдрийн ТУЗ-ийн хурлын 15 тоот тогтоолоор АЭХ-г 5 гишүүнтэйгээр томилж, хороон даргаар хараат бус гишүүн Г.Золжаргал даргалахаар батлагдсан. АЭХ нь бие даасан журмаар дотоод үйл ажиллагаагаа зохицуулахаар журмыг боловсруулан 2025-02 сард хуралдах ТУЗ ээлжит хурлаар хэлэлцүүлэхээр төслийг боловсруулан гишүүдээр хэлэлцүүлэх шатанд байна. Хороо нь чиг үүргийн хүрээнд 2024 онд хийсэн ажлын тайланг гаргаад байна. Нотлох баримт: 1. Компанийн дүрэм /2024-04-20 №03/ 2. ТУЗХ-ын тогтоол /2024-09-18 №15/ 3. ТУЗ болон хороодын 2024 оны тайлан	2	50%
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	Бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна. Компани ISO 9001:2015, ISO 14001:2015, FSSC 22000 гэсэн стандартуудыг нэвтрүүлж байгаа бөгөөд стандартын хэрэгжилтийг гадны аудит компани SGS компаниар шалгуулж гэрчилгээг гардаад байна.	Бид үйл ажиллагаандаа FSSC22000 Хүнсний аюулгүй байдлын иж бүрэн удирдлагын тогтолцоо, ISO 9001:2015 Чанарын удирдлагын тогтолцоо, ISO 14001:2015 Байгаль орчны удирдлагын тогтолцоо гэсэн 3 стандартыг нэвтрүүлэн хөндлөнгийн баталгаажуулах аудитанд амжилттай хамрагдаж гэрчилгээгээ авсан. Хөндлөнгийн баталгаажуулах аудитыг 2 үе шаттайгаар SGS компанийн хятад дахь салбар компаниас 5 аудитор ирж 2024 онд аудитлан, компани амжилттай шалгагдаж олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын шалгуурыг хангасан тул гэрчилгээ олгоод байна. 2025 онд баталгаажуулах аудитаар шалгуулна. Компанийн хувьд олон нийт, ард түмэн рүү чиглэсэн олон төрлийн арга хэмжээг зохион байгуулж, бусад байгууллага, компанитай хамтран ажиллаж, ард иргэдэд мэдлэг олгох сургалт, зөвлөгөө, өдөрлөг зэрэг олон хэлбэрээр нийгэмд эерэг нөлөө үзүүлэхээр тогтмол хийж	2	100%

		  	дадсан эмнэлэг, сувилал зэрэг эрүүл мэндийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2023 онд эхэлсэн томоохон ажлын нэг болох эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудлыг хөндөж, нийгэмд анхааруулга өгсөн "Хэнэгтэй Монгол эр хүн" төслийн талаар "Social impact 2024" арга хэмжээнд урилгаар оролцохдоо сайн туршлагаасаа хуваалцаж, төслийн үр дүнгийн талаар арга хэмжээнд оролцсон 100 гаруй салбарын мэргэжилтнүүдэд танилцуулсан юм. Энэ төслийн үр дүнд эрэгтэйчүүдийн тухай хэвшмэл ойлголтыг халах, өөрчлөх агуулгыг хөндөн, төслийг амжилттай хэрэгжүүлж давхардсан тоогоор 22 сая хүнд хүрч бодитоор эрүүл мэнддээ анхаарал хандуулах ойлголтыг эрэгтэйчүүдэд төрүүлж чадсан юм. 2024 онд иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор "Эрдэнэт хүн таны эрүүл биеийн төлөө-2024" уриан доор сувиллын өдөрлөг, арга хэмжээ, идэвхжүүлэлтийг зохион байгуулж 500 орчим амрагч, сувилуулагч иргэнийг хамруулан, өөрийн үйлдвэрийн бүтээгдэхүүнийг танилцуулсан. Мөн 123 орчим мянган дагагчтай Монос Хүнс фэйсбүүк хуудсаараа дамжуулан "MFC ADVICE" нэртэй эмчийн зөвлөгөө видеог тогтмол хүргэн ажиллаж байна. Мөн "Employee branding" болон "MFC family" видео контенттой болоод байна. 2019 оноос эхэлсэн хэрэглэсэн таягаа уул овоонд үлдэж байгальд хог хаягдал бий болгодог жишгийг өөрчлөх, бусдадаа хэрэгтэй зүйлээ хуваалцах дадлыг уриалсан таяг хандивлах буланг ГССҮТ-д "Monos care" аяны хүрээнд анх хийж байсныг үргэлжлүүлэн "Мөнгөн гүүр" эмнэлэгтэй хамтран "Таяг хандивлах цэг"-ийг бий болгосон зэрэг ажлуудыг хийгээд олон нийт, хувьцаа эзэмшигчиддээ тайлагнан ажиллаж байна Нотлох баримт: 1. БОНЗ тайлан https://monosfoods.mn/investor#tailan/ 2. https://monosfoods.mn/news/monos-hk-jln-jl-azhillagaa-olon-ulsad-dahin-h-leen-z-vsh-r-gdlu 3. https://monosfoods.mn/news		
21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийгдэхээр төлөвлөж байна.	ТУЗ нь компанийн комплайнсын хяналтыг ТУЗ-ийн дэргэдэх Аудит, эрсдэлийн хорооны удирдлага доор ажилладаг дотоод аудиторын үйл ажиллагаагаар дамжуулан хяналтаа тавин ажиллаж байна. Цаашид комплайнсын хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор	1	50%

	хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.		комплайнсын ажилтан, нэгжийн орон тоог үүсгэж компанийн бүтэц орон тоонд өөрчлөлт оруулахаар ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос төлөвлөн ажиллаж байна. Нотлох баримт: 1. Компанийн дүрэм /2024-04-20 №03/ 2. ТУЗ ҮАЖ /2024-11-22 №21/ 3. Дотоод аудитын дүрэм/2021-05-17 №05/		
ДҮН				7	88%
ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна					
22	6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	Бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна. 2024-04-20 өдрийн ХЭЭХ-аас баталсан дүрэмд КЭБАТ-ы цалин урамшуулалын дүн олголтын хэлбэр зэргийг дэлгэрэнгүй танилцуулгаар танилцуулан, төсөв, өмнөх оны гүйцэтгэл зэргийг танилцуулан төсвийг батлуулж хэвшсэн.	Жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ирэх оны ТУЗ-ийн төсвийг батлуулахдаа хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдэд ТУЗ-ийн гишүүдийн өнгөрсөн онд олгосон цалин урамшуулалыг тайлагнаж, төсвийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар батлан шийдвэрлэдэг. ТУЗ-ийн цалинг улиралд 1 удаа, ээлжит болон ээлжит бус хурлын оролцоогоор олгодог. ТУЗ төсвийг батлагдсан тогтоолын хамт МХБ-ийн нээлттэй сайтад байршуулдаг. 2024-04-20 өдөр хуралдсан ХЭЭХ-ын үеэр ТУЗ-ийн 2024 оны төсвийг дэлгэрэнгүй давтамж, олгох хэлбэрийн үнэлгээ бүхий хүснэгтийг ТУЗ-ийн хараат бус гишүүн, АХ-ы дарга О.Лхагвасүрэн дэлгэрэнгүй танилцуулсан. Нотлох баримт: 1. ХЭЭХ-ын материал /2024-04-20/ 2. ТУЗ ҮАЖ /2024-11-22 №21/ 3. https://www.facebook.com/MonosFoods/videos/2787430134743117	2	100%
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.	Хэрэгжүүлэн ажиллаж байна.	Энэ мэдээллийг нээлттэйгээр тайлагнадаг, мөн компанийн дүрмийн 7.17, ТУЗ ҮАЖ-ийн 9 дүгээр зүйлд тодорхой тусгасан. Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын цалин урамшууллын хэмжээг тогтоох, үндэслэл, шалгуурыг дахин шинэчлэн компанийн “Цалин хөлсний журам” -д тусган баталсан. Нотлох баримт: 1. Компанийн дүрэм /2024-04-20 №03/ 2. ТУЗ ҮАЖ /2024-11-22 №21/	2	100%
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын	Хэрэгжүүлэн ажиллаж байна.	Ирэх жилийн төсөвт болон жилийн эцсийн тайланд тусгайлан тусгадаг, мөн сар бүр цалин, урамшууллыг компанийн төлөвлөгөөний гүйцэтгэлтэй уялдуулан ТУЗ-ийн даргаар батлуулж байна.	2	100%

	үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шилгуурыг тусгана.		Гүйцэтгэх захирлын ажлыг жил бүр компанийн үйл ажиллагаа, ангийн үзүүлэлттэй уялдуулан дүгнэж гэрээг сунгах эсэх шийдвэрийг ТУЗ-ийн дэргэдэх НДХ болон ЦУХ-оор урьдчилан хэлэлцүүлж, гэрээг шинэчлэн байгуулж байна. 2024-02-16 өдрийн ТУЗ-ийн хурлын 29/02 тоот тогтоолоор ГЗ-ийн гэрээг сунгах, гүйцэтгэлийг дүгнэж тогтоол гаргасан. Нотлох баримт: 1. ТУЗ тогтоол /2024-02-19 №29/02/ 2. Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийг дүгнэх журам		
ДҮН				6	100%
ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ					
Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ					
25	7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	Хэрэгжүүлэн ажиллаж байна, цаашид процесс үйл ажиллагаанд нийцүүлэн байнгын сайжруулалт хийгдэн хэрэгжилтийг ханган ажиллах болно.	Компанийн тогтвортой өсөлтийг хангах, дунд болон урт хугацаанд үнэ цэнийг бий болгоход гол нөлөө бүхий оролцогч талууд болох 14000 гаруй хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, 270 орчим ажилтан, 200 гаруй бэлтгэн нийлүүлэгч, 8000 гаруй харилцагчидтай хамтран ажиллах явцад тэдний эрх ашгийг хангах талд анхааран ажиллаж, тэдний ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлж ажиллахад зорин ажиллаж байна. Компани энэ харилцааг зохицуулсан “Санал гомдол хүлээн авах, шийдвэрлэх журам” -ыг мөрдөн ажилладаг бөгөөд цаашид компанийн зүгээс оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талд дээрх журамд болон “Худалдан авалтын журам”-д нэмэлт өөрчлөлт сайжруулалтыг хийгээд байна. Нотлох баримт: 1. Санал гомдол хүлээн авах журам /ГЗ тушаал 2018-11-30 №169/ 2. Худалдан авалтын журам /ГЗ тушаал 2023-12-28 №А/39/	2	100%

26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	Хэрэгжүүлэн ажиллаж байна.  ҮНЭТ ЗҮЙЛС УНДГАЙН БҮЛЭГЭЙН ХАМТРАН АЖИЛЛАХДАА АЖИЛЛАХДАА  ЭРХЭМ ЗОРИЛГО УНДГАЙН БҮЛЭГЭЙН ХАМТРАН АЖИЛЛАХДАА АЖИЛЛАХДАА	Компани анх нээлттэй хувьцаат компани болохдоо олон нийтэд танилцуулж байсан проспектуст тулгуурлан компанийн үндсэн богино болон урт хугацааны стратегийг баримтлан оролцогч талуудыг мэдээллээр хангах, хамтран ажиллах боломжит хувилбарыг сонгон ажиллаж байна. 2023-10-05 одор Монос хүнс ХК-ийн ажилтнуудын төлөөлөл “Retreat” арга хэмжээний үеэр компанийн үнэт зүйлс, соёл, алсын харааг цаг үетэйгээ нийцүүлэн шинэчлэн өөрчилж 2024 онд батлахдаа компанийн “Үнэт зүйлс” болон “Эрхэм зорилго”-доо оролцогч талуудаа тусгаснаар компанийн голчлон анхаарах асуудлын нэг гэдгийг бататгаад байгаа юм. Компани уламжлал болгон жилд 2 удаа зохион байгуулж явуулдаг “Retreat” арга хэмжээг 2024-10-22-наас 2024-10-23 өдрүүдэд “Highway” гэсэн нэрийн доор зохиож, энэ арга хэмжээнд С түвшний менежерээс дээш ажлын байранд ажиллаж байгаа, албадын төлөөлөл 46 ажилтан оролцон, компанийн 2025-2027 оны стратеги, хэтийн төлөвлөлтийг хэлэлцэж, богино болон урт хугацааны стратеги зорилтуудаа эхний байдлаар томьёолж, ТУЗ дэргэдэх СБХХ болон ТУЗ-ын хурлаар хэлэлцүүлэн зөвлөмж авч батлуулсан юм. Нотлох баримт: https://monosfoods.mn/business https://www.facebook.com/groups/1711166335787657/search/?q=retreat	2	100%
27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийгдэхээр төлөвлөж байна.	Компанийн зүгээс хийж буй ажлыг цаг алдахгүй мэдээлэх, үүгээр оролцогч талуудыг мэдээллээр тогтмол хангахад чиглэн ажилладаг. Мөн компанийн хувьцаа эзэмшигчдийн фэйсбүүк группыг үүсгэн тогтмол мэдээлэл пост оруулах, шинэ болон сав баглаа өөрчлөгдсөн бүтээгдэхүүний мэдээллээр хангах, санхүү тайлан, засаглалын үйл ажиллагаатай танилцах, үйлдвэрийн процесс, компанийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, хувьцааны ханшийн өөрчлөлт зэрэг мэдээллийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран оруулж, шууд дамжуулалт хийх, видео бичлэг үзэх боломжоор ханган мэдээллэж, комментоор сэтгэгдлийг хүлээн авч хариулах зэргээр сошиал орчинг харилцааны бас нэгэн хурдацтай талбар болгон ашиглаж байна. Нотлох баримт: Компанийн вэб хуудас https://monosfoods.mn/	2	100%

			2. Компанийн фэйж хуудас /https://www.facebook.com/MonosFoods 3. МХБиржийн вэб хуудас /https://mse.mn/mn/company/551/		
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	Бүрэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийгдэхээр төлөвлөж байна.	Компани “Хөдөлмөрийн дотоод журам”, “Олон нийттэй харилцах журам”, “Санал гомдол хүлээн авах журам” зэрэг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа журмаар ажилчид, хэрэглэгчид, ханган нийлүүлэгчид, эрх бүхий байгууллага, хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, хэвлэл мэдээлэл, төрийн болон төрийн бус бусад байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллаж байна. Нотлох баримт: 1. Хөдөлмөрийн дотоод журам / ГЗ тушаал 2021 2. Санал гомдол хүлээн авах журам /ГЗ тушаал 2018-11-30 №169/	2	100%
ДҮН				8	100%
НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ					
ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно					
29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийгдэхээр төлөвлөж байна.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 13 дахь хэсэгт ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын баримталбал зохих ёс зүйн хэм хэмжээг тодорхойлж өгсөн. Компанийн нийт ажилтнуудын мөрдвөл зохих ёс зүйн зарчим болон ёс зүйн хэм хэмжээг нарийвчлан заасан “Ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн сайжруулахаар ажиллаж байна. ТУЗ-ийн дэргэдэх НДХ-оос “Шүгэл үлээх журам” төслийг боловсруулан гишүүдээс санал авч хэлэлцүүлж байна. 2025-02 сард хуралдах ТУЗ ээлжит хурлаар батлагдана Нотлох баримт: 1. Ажилтны ёс зүйн дүрэм 2. Шүгэл үлээх журам	2	100%
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.	Компани “Ёс зүйн дүрэм”, “Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журам”-д зааснаар болон жил бүр хөндлөнгийн судалгааны байгууллагаар нийт ажилтнуудаас манлайлал, удирдлагыг дүгнэдэг асуулга багтсан “Соёлын судалгаа”, “Энгэйжментийн судалгаа” зэргийг авч хэвшсэн.	2023 онд нийт ажилтнуудыг хамарсан судалгааг “Аксиом Инк” ХХК судалгааны компаниар гүйцэтгүүлсэн. Судалгаанд Монос хүнс ХК-ийн 226 ажилтан хамрагдаж 117 ажилтан цахимаар, 57 ажилтан цаасаар судалгааг бөглөсөн. Судалгааны асуулганд манлайлал, удирдлагын баг, шууд удирдлага, байгууллагын тогтолцоо, соёл, ёс зүйн талаар асуулгууд багтсан байсан бөгөөд ажилтан ажиллах нөхцөл, цалин урамшуулал, шийдвэр гаргалт, ажилтны сэтгэл ханамж зэрэгтэй холбоотой асуулгуудаар дамжуулан ажилтны шүгэл үлээх тогтолцоог зохицуулсан. Судалгааны дүнд үндэслэн удирдлагын баг, ТУЗ цаашид хийх үйл ажиллагаа шийдвэр гаргалт зэргийг төлөвлөн ажилладаг. 2024 онд энэхүү судалгааг Монос групп, түүний нэгдэлд хамаарах	2	100%

			нийт 13 компанийн 1508 ажилтанг хамарсан “Энгэйжментийн судалгаа” нэрээр 77 асуулгаар 5 сард авч нэгтгэл тайланг танилцуулсан. Нотлох баримт: 1. Ажилтны энгэйжментийн судалгаа 2. Шүтэл үлээх журам		
31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	“Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журам”-ыг 2023-05-10 өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар хээлцүүлэн 06/05 тоот ТУЗ-ийн тогтоолын хавсралтаар батласан.	Компанийн хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс шийдвэр гаргах түвшний эрх бүхий албан тушаалтнуудаас ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлэх үүднээс уг журмыг батласан. Журмын хавсралтаар КЭБАТ-аас авах нэгдмэл сонирхлын мэдүүлгийн маягтыг батласан бөгөөд бөглүүлэн авсан. Журамд КЭБАТ нь хэзээ хэнд ямар байдлаар мэдүүлгийг гаргаж байхыг зохицуулсан. Нотлох баримт: 1. Ашиг сонирхлыг зохицуулах журам /ТУЗ тогтоол 2023-05-10 №06/05 /	2	100%
ДҮН				6	100%
ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ					
Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана					
32	9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.	Бүрэн хэрэгжүүлэн хэвшүүлэн ажиллаж байна.	Монос хүнс ХК-ийн вэб хуудаст Хувьцаа эзэмшигчдэд талбарт хувьцаа эзэмшигчдэд тусгайлан шаардлагатай мэдээллийн талбарыг үүсгэсэн. Энэ талбар нь дотроо • Хувьцааны тухай • Компанийн тухай • Санхүүгийн мэдээлэл • Үйл ажиллагааны тайлан • Төлөөлөн удирдах зөвлөл • Хувьцаа эзэмшигчдийн хурал гэсэн дэд талбаруудтай. Талбар бүрт мэдээллийг шинэчлэн оруулан мэдээлж тайлагнадаг. Мөн Монголын хөрөнгийн биржийн вэб хуудаст мэдээллийг тухай бүрд шинэчлэн байршуулж байна. Нотлох баримт: 1. Компанийн вэб хуудас https://monosfoods.mn/ 2. Компанийн фэйж хуудас https://www.facebook.com/MonosFoods 3. МХБиржийн вэб хуудас https://msc.mn/mn/company/551	2	100%
33	9.2. Компани хоронго оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох	Бүрэн хэрэгжүүлсэн, нэмэлт сайжруулалт хийхээр төлөвлөж байна.	Монос хүнс ХК нь хувьцаа эзэмшигчиддээ мэдээллийг шуурхай түгээх үүднээс компанийн вэб хуудас, фэйсбүүк групп, Монос хүнс ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн фэйсбүүк групп зэрэг цахим талбаруудыг тогтмол ашиглан мэдээлэл, сургалт, мэдлэг, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан,		

	цахим сувгийг хөгжүүлнэ.		зар, шинэ бүтээгдэхүүний танилцуулга зэргийг тогтмол хүргэж байна. Мөн хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр төлөвлөгөөний хүрээнд “Голомт капитал”, “Таван богд капитал”, “Ти Ди Би секьюритис” ҮЦК БДК-уудтай хамтран ажиллах гэрээг байгуулж, хөрөнгө оруулагчдад хувьцааны хөрөнгө оруулалт хийхийн ашиг тус, хөрөнгийн зах зээлийн мэдлэг олгох сургалт мэдээлэл, Монос хүнс ХК-ийн хувьцааны мэдээлэл, компанийн ашигт ажиллагааны талаар тогтмол мэдээлж, цахим мэдээллийг түгээн хамтран ажиллаж байна. Нотлох баримт: 1. Компанийн вэб хуудас https://monosfoods.mn/ 2. Компанийн фэйж хуудас https://www.facebook.com/MonosFoods 3. Хувьцаа эзэмшигчдийн фэйс грууп https://www.facebook.com/groups/1030367210486131/	2	100%
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	Бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна.	Монос хүнс ХК нь 2019-06 сард анх хувьцаагаа хөрөнгийн биржээр дамжуулан нээлттэй арилжаалснаас хойш ХЭЭХ-ыг 7 удаа хуралдуулаад байна. Хурлын талаар товч мэдээлбэл: 1.2019-06-26 танхим 3700 гаруй ХЭ, хуралд 78% ирцтэй хуралдаж 4 асуудлыг хэлэлцэн батласан. 2.2020-04-27 цахим 4000 гаруй ХЭ, хуралд 77,72% ирцтэй оролцож 5 асуудлыг хэлэлцэн баталсан. 3.2021-03-31 цахим 4691 ХЭ, хуралд 81,48% ирцтэй оролцож 4 асуудлыг хэлэлцүүлсэн. 4.2022-04-23 нийт 26000 хувьцаа эзэмшигчтэй Монголын ТОП 5 ХК (Мандал даатгал ХК, Мандал ирээдүйн өсөлт ХОС, Түмэн шувуут ХК, Цэнтрал экспресс ХК, Монос хүнс ХК) компаниудтай хамтран Хөрөнгө Оруулалтын Экспо-г амжилттай зохион байгуулж, ХЭЭХ-д 6500 хувьцаа эзэмшигчдээс 215 хувьцаа эзэмшигч 71,55% ирц бүрдэж 5 асуудлыг хэлэлцсэн. 5.2023-04-29 цахим, танхим хосолсон хэлбэрээр зохион байгуулж, 9665 ХЭ-ээс 84.14%-ийн ирцтэй хуралдаж 5 асуудлыг хэлэлцүүлсэн. 6.2024-04-20 цахим, танхим хосолсон хэлбэрээр зохион байгуулж, 12,880 ХЭ-ээс 74.84%-ийн ирцтэй хуралдаж 5 асуудлыг хэлэлцсэн. Онцлог нь: ХЭЭХ-ыг өнгөрсөн жилийн ХЭЭХ дээрээ амлаж танилцуулж байсан MFC 2.0 төсөл буюу шинэ үйлдвэрийн байрны	2	100%

			хурлын танхимд зохион байгуулж, хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдаа шинэ үйлдвэрийн барилгаа танилцуулж, 2023 онд хийсэн бүтээсэн ажлаа нүдээр үзэн тайлагнах боломжийг олгосон хурал байлаа. 7.2024-09-09 ээлжит бус хурлыг цахимаар хуралдуулсан. Хуралдах шаардлага нь 2024-04-20 өдрийн ээлжит хурлаас компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж ТУЗ гишүүний тоог 11, хороодын тоог 4 болгосон заалтыг тусгасан. Заалтын хэрэгжилтийг хангах үүднээс ЭБХ-ыг зарлан хуралдуулж ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг хугацаанаас нь өмнө чөлөөлж, дахин кумулятив аргаар хараат 6, хараат бус 5, нийт 11 гишүүнийг сонгосон. Нотлох баримт: 1. СЗХ-д хүргүүлсэн ХЭЭХ-ын материал		
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Бүрэн хэрэгжүүлсэн, нэмэлт сайжруулалт хийхээр төлөвлөж байна.	КТХ-д заасан ХЭ-ийн бүрэн эрхийн хэмжээнд шийдвэрлэх асуудлыг хууль болон зохицуулагч байгууллагаас гаргасан журмын хүрээнд хэлэлцэх асуудалд тусган ХЭЭХ-д оролцсон ХЭ-ийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэх боломжтой. КТХ-д заасан засаглалын бүрэн эрхийн хэмжээнд ХЭ, ТУЗ, ГЗ нарын эрх хэмжээний хүрээнд асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлж байна. Энэ нь ТУЗ-аас гаргасан тогтоолоор баталгаажна. Нотлох баримт: 1. МХБ сайгад байршуулсан тогтоол /https://mse.mn/mn/company/551/	2	100%
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн, нэмэлт сайжруулалт хийхээр төлөвлөж байна.	Сонирхлын зөрчилтэй хэлцэл болон нэгдмэл сонирхолтой хэлцлийг Компанийн тухай хуульд зааснаар зохицуулдаг. Компанийн дүрмийн 7.16.4-д зааснаар Аудит, эрсдэлийн хороо хяналтаа тавьж, тухайн хэлцэлд сонирхлын зөрчилгүй гишүүдийн олонхийн шийдвэрээр асуудлыг шийдвэрлэж байна. 2024 онд сонирхлын зөрчилтэй хэлцэл 1 хийгдсэн. Компани тухайн жилд хийсэн СЗХ болон ИХХ-ийн мэдээлэл, шийдвэр гаргалтыг хөндлөнгийн аудитын байгууллагад хянуулж хөндлөнгийн аудитын төлөөллөөр ХЭЭХ дээр тайлагнадаг. Нотлох баримт: 1. Компанийн дүрэм /2024-04-20 №03/ 2. ТУЗ ҮАЖ /2024-11-22 №21/ 3. Ашиг сонирхлыг зохицуулах журам /2023-05-10 №06/05 /	2	100%
ДҮН				10	100%
НЭГДСЭН ДҮН				71	98.6%